



Инфляцын тайлан

2024 | 12-р сар



АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР.....	3
МӨНГӨНИЙ БОДЛОГЫН СТРАТЕГИ.....	4
МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ШИЙДВЭР	5
ТОЙМ.....	6
1. ИНФЛЯЦ	8
1.1. Инфляцын цаашдын төлөв	8
1.2. Инфляцын гүйцэтгэл.....	9
1.3. Төсөөллийн зөрүү.....	10
2. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ	11
2.1. Эдийн засгийн өсөлтийн цаашдын төлөв	11
2.2. Эдийн засгийн өсөлтийн гүйцэтгэл.....	14
3. ДОТООД ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН.....	16
3.1. Хөдөлмөрийн зах зээл.....	16
3.2. Мөнгө, санхүүгийн зах зээл	18
3.2.1. Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд.....	18
3.2.2. Хүү.....	20
3.2.3. Валютын ханш.....	21
3.2.4. Хөрөнгийн зах зээл	23
3.3. Нэгдсэн төсөв болон Засгийн газрын өр.....	25
4. ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ОРЧИН	26
4.1. Эдийн засгийн гадаад орчны төсөөлөл	26
4.2. Экспортын үнийн төлөв.....	28
4.3. Төлбөрийн тэнцэл	29

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

Товчилсон үг	Тайлбар
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БӨИ	Барилгын өртгийн индекс
ГЕГ	Гаалийн Ерөнхий Газар
ГЦА	Гадаад цэвэр актив
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГ	Засгийн Газар
МБХ	Мөнгөний Бодлогын Хороо
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОУВС	Олон Улсын Валютын Сан
ОХУ	Оросын Холбооны Улс
ТБҮЦ	Төв банкны үнэт цаас
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ХБҮЦ	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас
ХОС	Хөрөнгө оруулалтын сан
ХҮИ	Хэрэглээний үнийн индекс
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
EIU	Economic Intelligence Unit
NEER	Nominal effective exchange rate (Нэрлэсэн үйлчилж буй ханшийн индекс)
REER	Real effective exchange rate (Бодит үйлчилж буй ханшийн индекс)

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН СТРАТЕГИ

Төв банкны тухай хуульд **Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн тогтвортой байдлыг хангах** гэж тодорхойлсон байдаг. Энэ зорилтын хүрээнд Монголбанк хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг дунд хугацаанд зорилтот түвшний орчимд тогтворжуулах бодлогыг “Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл”-д тусган хэрэгжүүлж байна. Инфляцыг нам түвшинд тогтворжуулснаар иргэдийн бодит орлого, хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалж, банк санхүүгийн тогтолцооны тогтвортой байдал хангагдах нөхцөлийг бүрдүүлэх төдийгүй хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг дэмжинэ. Монголбанк **инфляцыг дунд хугацаанд жилийн 5 хувь орчимд, +/-2 нэгж хувийн интервалд тогтворжуулахыг зорьж** байна.

Монголбанкнаас мөнгөний бодлогын хүрээнд бодлогын хүүг өөрчилснөөр санхүүгийн зах зээлийн хүү, мөнгө, зээлийн эрэлт, нийлүүлэлтэд, улмаар үйлдвэрлэлийн хэмжээ, хөрөнгийн үнэ, хүлээлт, валютын ханш, дотоод эрэлтэд нөлөөлөх замаар инфляцын түвшин, түүний хүлээлтийг тогтворжуулахыг зорьдог. Макро зохистой бодлогын хүрээнд системийн хэмжээнд мөрдүүлэхүйц банкны зохистой харьцааны хэрэгслүүдээр дамжуулан банкны зээлийн хэт өсөлт, үүний аль нэг салбар, бүтээгдэхүүн эсвэл гадаад валютад хэт төвлөрсөн байдлыг оновчтой удирдах зэрэгт чиглэсэн арга хэмжээг мөнгөний бодлогын арга хэрэгслүүдтэй хослуулан хэрэглэх стратегийг баримталж байна.

Монголбанк мөнгөний бодлогын үр нөлөөг сайжруулахын тулд олон нийттэй харилцах харилцааны нээлттэй байдалд ач холбогдол өгч байна. Иймд Монголбанк макро үзүүлэлтүүдийн гүйцэтгэл, инфляц, эдийн засгийн ойрын төлөв байдал, түүнд нөлөөлж буй гол хүчин зүйлсийг Инфляцын тайланд танилцуулж, улирал тутам олон нийтэд мэдээлж байна. Төв банкны зорилтод нийцтэй, инфляцын төсөөлөлд үндэслэн авч хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын арга хэмжээ, үр дүнг олон нийтэд нээлттэй танилцуулснаар бодлогын ил тод байдлыг хангах, Монголбанканд итгэх итгэлийг дээшлүүлэх замаар зах зээлд оролцогчдод ирээдүйн талаар мэдээлэл өгөх, хүлээлтийг удирдахыг зорьдог.

Монголбанкны мөнгөний бодлогын үйл ажиллагааны зорилт нь банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү байдаг. Энэ зорилтын хүрээнд Монголбанкнаас нээлттэй захын үйл ажиллагаа, хүүний нэгдсэн бодлого, репо санхүүжилт болон бусад мөнгөний бодлогын арга хэрэгслүүдийг ашиглаж байна. Мөнгөний бодлогын шилжих механизм ёсоор банк хоорондын захын хүүний өөрчлөлт нь хадгаламж, зээлийн хүү болон бусад хөрөнгийн үнэд нөлөөлснөөр инфляц болон тэдгээрийн ирээдүйн төлөвийн талаарх хүлээлтэд нөлөөлдөг. Ингэхдээ бодлогын хэрэгсэл нь эцсийн зорилт болох эдийн засгийн идэвхжил, инфляцад тодорхой хугацааны хоцролттой нөлөөлдөг.

ТБҮЦ-ны арилжаа нь банк хоорондын захын богино хугацаатай хүү, банкуудын эх үүсвэрийн хэлбэлзлийг удирдах замаар мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл болж байна. Түүнчлэн бодлогын хүүний коридор системтэй уялдуулан мөнгөний бодлогын бусад хэрэгслүүдийн хүү тодорхойлогддог.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ШИЙДВЭР

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2024 оны 12 дугаар сарын 12, 13-ны өдрийн ээлжит хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, гадаад орчны эрсдэлийг харгалзан:

1. Бодлогын хүүг 10 хувьд хэвээр хадгалах;
2. Банкнуудын төгрөгийн болон гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 1 нэгж хувиар тус тус нэмэгдүүлж, харгалзан 11 хувь болон 16 хувьд хүргэхээр шийдвэрлэлээ.

Мөнгөний бодлогын 2024 оны 12-р сарын 13-ны өдрийн мэдэгдлийн дэлгэрэнгүйг [эндээс](#) уншина уу.

Инфляцын тайланд орсон тоон өгөгдөл, зураг, хүснэгтийг [дараах](#) линкээр орж татан авах боломжтой.

ТОЙМ

Эрэлтийн болон зардлын шалтгаантай хүчин зүйлсийн нөлөө хүлээлтээс өндөр байгаагаас шалтгаалан инфляцын төсөөлөл өмнөхөөс нэмэгдлээ. Инфляц ирэх улирлуудад зорилтоос давж эрчимжин, 2026 оноос Төв банкны зорилтот интервалд тогтворжихоор байна. Уул уурхайн салбарын үйлдвэрлэл тэлэх, төсвийн төлөв сулрах, зудын хүндрэлийн сөрөг нөлөө арилах зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр эдийн засгийн өсөлт ирэх онд эрчимжих хүлээлт хэвээр байна. Геополитикийн нөхцөл байдалтай холбоотой тодорхой бус байдал гадаад орчинд өндөр байгаа ч томоохон эдийн засгуудад мөнгөний бодлогын төлөв зөөлөрч байгаа нь дэлхийн эдийн засгийн өсөлтийн төлөвт эергээр нөлөөлж байна. Монголбанкны Мөнгөний бодлогын хороо инфляц, эдийн засгийн өсөлтийн төлөв, банк, санхүүгийн зах зээлийн нөхцөл байдал, гадаад орчны төлөвийг харгалзан 2024 оны 12 дугаар сард бодлогын хүүг 10 хувьд хэвээр хадгалах шийдвэрийг гаргалаа. Тус бодлогын шийдвэрийг гаргахад ашигласан эдийн засаг, зах зээлийн өнөөгийн байдал, суурь төсөөллийн тооцооллыг энэхүү Инфляцын тайлангаар танилцуулж байна.

Инфляц ирэх улирлуудад өмнөх төсөөллөөс нэмэгдэн эрчимжиж, ирэх оны сүүлээс алгуур буурах хүлээлттэй байна. 2024 оны 11 дүгээр сард инфляц улсын хэмжээнд 8.1 хувь, Улаанбаатар хотод 7.9 хувьтай гарч өмнөх сараас нэмэгдлээ. Ийнхүү инфляц өсөхөд цахилгааны үнийн өсөлт голлон нөлөөлсний зэрэгцээ дотоод эдийн засгийн сэргэлт, цалингийн өсөлттэй холбоотойгоор үйлчилгээ, түрээс, импортын барааны үнэ хүлээлтээс өндрөөр өссөн нь нөлөөлөв. Ирэх онд эдийн засгийн өсөлт үргэлжилж, төсвийн зардал тэлснээр эрэлтийн шинжтэй инфляцын дарамт нэмэгдэх, өрхийн болон аж ахуйн нэгжийн дулааны төлбөр, ус сувгийн үнэ өсөх зэрэг нь шууд болон зардлын сувгаар дамжин инфляцыг нэмэгдүүлэх хүлээлттэй байна. Улмаар инфляц 2025 оны туршид Төв банкны зорилтот интервалыг давж нэмэгдэх бөгөөд оны сүүлээс инфляцын эрч саарч, 2026 онд зорилтот түвшинд хүрч тогтворжихоор байна.

Эдийн засгийн өсөлтийн төсөөллийг 2024 онд бууруулсан бол ирэх оны төсөөллийг бага зэрэг нэмэгдүүлээ. Эдийн засгийн өсөлт 2024 оны эхний гурван улирлын байдлаар 5.0 хувь гарав. Оюу толгойн алт, зэс болон Эрдэнэт үйлдвэрийн зэсийн баяжмалын олборлолт буурсантай холбоотойгоор уул уурхайн салбарын өсөлт удааширч, боловсруулах болон барилгын салбарын үйлдвэрлэл буурсан нь өсөлт хүлээлтээс бага байхад нөлөөлөв. Үүнтэй уялдан 2024 оны өсөлтийн төсөөллийг 5.2 хувь болгож буурууллаа. Эдийн засгийн өсөлтийг 2024 онд уул уурхайн үйлдвэрлэлийг дагасан тээвэр, худалдааны салбарын өсөлт болон үйлчилгээ, бүтээгдэхүүний цэвэр татварын өсөлт голлон тэтгэхээр байна. Харин 2025 онд нүүрсний олборлолт өмнөхөөс нэмэгдэх, Оюу толгойн үйлдвэрлэл эрчимжиж, зудын хүндрэл арилахын зэрэгцээ төсвийн төлөв сулрах зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр эдийн засгийн өсөлт эрчимжих төлөвтэй.

Гадаад орчны төлөв өмнөхөөс өөрчлөлтгүй байна. Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төлөв тайлант улиралд хэвээр хадгалагдсан бөгөөд хөгжингүй орнуудын мөнгөний бодлогын төлөв сулрах чиглэлд өөрчлөгдөж байгаа нь цаашид глобал өсөлтийг дэмжихээр байна. Сэргээгдэх эрчим хүч, цахилгаан автомашины үйлдвэрлэл нэмэгдэж байгаагийн зэрэгцээ геополитикийн нөхцөл байдалтай холбоотой тодорхой бус байдал үргэлжилсэн хэвээр байгаа

нь түүхий эдийн зах зээлд зэс, алтны үнэ өсөхөд нөлөөлөв. Харин БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарах хүлээлт хэвээр байгаа нь нүүрс, төмрийн хүдэр зэрэг манай экспортын гол түүхий эдийн үнэ үргэлжлэн буурах нөлөөг үзүүлэхээр байна. АНУ-ын мөнгөний бодлогын төлөв үргэлжлэн суларч, эдийн засгийн өсөлт хүлээлтээс өндөр гарсан бөгөөд цаашид шинээр сонгогдсон ерөнхийлөгчийн хэрэгжүүлэх гадаад худалдаа, тарифын бодлого зэрэг нь өсөлтийн төлөвийг тодорхойлох хүлээлт бий боллоо.

Төлбөрийн тэнцэл 2024 оны эхний 9 сард 251 сая ам.доллар, 3 дугаар улиралд 193 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Тайлант улиралд төлбөрийн тэнцэл алдагдалтай гарахад урсгал дансны алдагдал 784 сая ам.долларт хүрч тэлсэн нь голлон нөлөөлөв. Хэдийгээр алт, зэсийн үнэ өндөр хадгалагдаж, нүүрсний экспортын биет хэмжээ өссөн боловч нүүрсний үнэ буурсан нөлөөгөөр экспортын өсөлт өмнөх онтой харьцуулахад саарлаа. Мөн хувийн аялал, боловсрол, эрүүл мэнд зэрэг үйлчилгээний зориулалттай гадаад зардлууд нэмэгдсэн бөгөөд эдийн засгийн идэвхжил болон төсвийн зардал тэлсэнтэй холбоотойгоор импортын өсөлт өндөрт хэвээр хадгалагдаж байна. Харин санхүүгийн данс 2024 оны 3 дугаар улиралд 646 сая ам.долларын ашигтай гарсан бөгөөд үүнд Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилт гол нөлөөг үзүүлжээ.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт эргэн саарлаа. Оны эхнээс эрчимжиж 6 дугаар сард 31.9 хувьд хүрч байсан мөнгөний нийлүүлэлтийн өсөлт сүүлийн саруудад саарч, 2024 оны 10 дугаар сард 25.1 хувьд хүрлээ. Ийнхүү мөнгөний нийлүүлэлтийн өсөлт буурахад төлбөрийн тэнцлийн алдагдалтай холбоотойгоор гадаад цэвэр активын өсөлт саарсан нь голлон нөлөөлөв. Мөнгөний нийлүүлэлтийг актив талаас зээлийн өсөлт, эх үүсвэр талаас төгрөгийн эх үүсвэр тайлбарласан хэвээр байна. Банкны систем дэх нийт зээлийн өсөлт 2024 оны 10 дугаар сард 31.4 хувьд хүрч нэмэгдсэн ба зээлийн ангиллаар авч үзвэл хэрэглээ, ипотекийн зээлийн өсөлт тогтвортой хадгалагдаж, бизнесийн зээлийн өсөлт үргэлжлэн эрчимжин 31.3 хувьд хүрлээ. Үүнээс эдийн засгийн салбаруудаар авч үзвэл худалдаа, үйлчилгээ, уул уурхайн салбарын зээл бизнесийн зээлийн өсөлтийн 64 орчим хувийг бүрдүүлж байна.

Инфляцын төсөөлөл өмнөхөөс нэмэгдэж, 2025 онд инфляц Төв банкны зорилтот интервалаас давах хүлээлттэй болов. Инфляцын цаашдын төлөвт цалин, тэтгэврийн өсөлт, төсвийн тэлэлтийг дагасан эрэлтийн шалтгаантай дарамт нэмэгдлээ. Түүнчлэн Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлэхээр төлөвлөж буй мега төслүүдийн санхүүжилт нь төлбөрийн тэнцэл, валютын ханшаар дамжин инфляцын дарамт учруулах, цахилгаан дулааны төлбөрийн өсөлт нь зардлын болон хүлээлтийн сувгаар инфляцыг өдөөх эрсдэл нэмэгдэж байна. Цаашид эдийн засгийн идэвхжил, инфляцын өрнөл болон гадаад эдийн засгийн орчинд гарч буй өөрчлөлт зэргийг харгалзан үзэж мөнгөний бодлогын шаардлагатай алхмыг тухай бүрт авч хэрэгжүүлнэ.

1. ИНФЛЯЦ

1.1. Инфляцын цаашдын төлөв

Төсөөлөлд ашигласан гол таамаглалт нөхцөлүүд:

- Бодлогын хүү 2024 оны 4 дүгээр улирал, 2025 оны 1 дүгээр улиралд 10 хувь;
- Нийлүүлэлтийн аливаа шок үүсэхгүй;
- АИ-92 шатахууны үнэд өөрчлөлт орохгүй;
- Өрхийн цахилгааны төлбөр энэ оны 11 дүгээр сараас 30-85 хувиар, ус сувгийн төлбөр ирэх оны эхнээс 25 хувиар, дулааны төлбөр ирэх оны 5 дугаар сараас 85 хувиар тус тус нэмэгдэх зэрэг таамаглалт нөхцөлүүд дээр үндэслэн суурь төсөөллийг боловсрууллаа.

Инфляцын төсөөлөл өмнөхөөс нэмэгдлээ. Цалингийн өсөлт, дотоод эдийн засгийн идэвхжлийг дагаад үйлчилгээ, түрээс, импортын барааны үнэ хүлээлтээс өндрөөр өсөж, эрэлтийн шалтгаантай үнийн дарамт нэмэгдсэн нь инфляцын төсөөлөл нэмэгдэх гол шалтгаан болж байна.

Цаашлаад ирэх онд төсөв тэлж, эдийн засгийн идэвхжил нэмэгдэхийн зэрэгцээ төрийн зохицуулалттай үйлчилгээний үнэ өсөж, үүнийг дагасан дам нөлөө зэрэг эрэлт болон зардлын шалтгаантай инфляцын дарамт нэмэгдэж, инфляц өмнөх төсөөллөөс өсөхөөр байна.

Инфляц энэ оны 4 дүгээр улиралд дунджаар 7.5 хувь, 2025-26 онд харгалзан 8.8 хувь, 6.0 хувь байх төсөөлөлтэй байна. Хүнсний инфляц ирэх улирлуудад алгуур нэмэгдэхээр байна. Үүнд, эдийн засгийн идэвхжил нэмэгдэх, дэлхийн зах зээл дэх хүнсний үнэ өсөх, ханш сулрах зэрэг нь гол

нөлөө үзүүлэхээр байна. Хүнсний бус инфляцын хувьд мөн өсөх төсөөлөлтэй. Тодруулбал, төсвийн тэлэлт, эдийн засгийн идэвхжил нэмэгдэх нь эрэлтийн шалтгаантай инфляцын дарамтыг нэмэгдүүлэхээр байна. Түүнчлэн, ус суваг, цахилгаан, дулаан зэрэг төрийн зохицуулалттай үйлчилгээний үнийн өсөлтийн шууд болон дам нөлөө, төгрөгийн ханш алгуур сулрах, гадаад үнэ өсөх зэрэг нь зардлын шинжтэй инфляцын дарамтыг өсгөхөөр байна. Ийнхүү эрэлт болон зардлын шалтгаанаар инфляц ирэх оны эхний хагаст эрчимжиж, ирэх оны сүүлээс инфляцын эрч саарах төсөөлөлтэй байна.

Зураг 1.1 Инфляцын өмнөх болон одоогийн төсөөлөл



Эх сурвалж: Монголбанк

Дунд хугацаанд дотоод эдийн засгийн идэвхжил тогтворжиж, эрэлтийн шалтгаантай үнийн дарамт буурах, гадаад үнэ саарах зэрэг нөлөөгөөр инфляц алгуур буурч, 2026 оны сүүлийн хагаст зорилтын голчийн орчимд тогтворжихоор байна.

Хүснэгт 1.1 Инфляцын төсөөлөл

	2024.III	2024*	2025*	2026*
		<i>Төсөөлөл</i>		
Инфляц ¹	5.9	7.5 [7.0-8.0] ²	8.8 [6.6-11.0]	6.0 [3.5-8.5]

Эх сурвалж: Монголбанк

¹ ХҮИ-ээр хэмжигдэх инфляц, 4 дүгээр улирлын дундаж

² 30 хувийн магадлалтай итгэх интервал


Инфляцын төсөөллийг өөрчилж болзошгүй тодорхой бус байдал:

Эрсдэл, тодорхой бус байдал	Магадлал	Нөлөө
Монгол Улсын ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 14 мега төсөл хэрэгжүүлэхээр тусгаснаас 4 төсөл нь төсөвт туссан бөгөөд бусад төслийн санхүүжилт хэрхэн шийдвэрлэгдэх нь тодорхойгүй байна. Эдгээр томоохон төслүүд дотоод эх үүсвэрээс санхүүжүүлэх тохиолдолд төлбөрийн тэнцлийн алдагдал огцом тэлж, ханшаар дамжин инфляцын дарамтыг нэмэгдүүлэхээр байна.	Дунд	Өндөр
Цалин, тэтгэврийн өсөлт, өрхийн хэрэглээний өсөлтийг дагаад эрэлтийн шалтгаантай инфляцын дарамт хүлээлтээс нэмэгдэж эхэллээ. Ирэх онд дотоод эдийн засгийн идэвхжил нэмэгдэхтэй зэрэгцээд төсвийн тэлэлт, мега төслүүд үргэлжилж төлбөрийн тэнцэл, ханшид дарамт учирвал инфляц эрэлтийн болон зардлын шалтгаанаар өдөөгдөх эрсдэл үүснэ.	Дунд	Өндөр
Аж ахуйн нэгжүүдийн цахилгааны төлбөр 11-р сараас, дулааны үнэ ирэх оны 5 сараас нэмэгдэхээр байна. Суурь төсөөлөлд аж ахуйн нэгжүүдийн цахилгаан, дулааны үнэ нэмэгдэхэд инфляцад үзүүлэх нөлөөг тусгасан ч хүлээлтээр дамжаад үнэ эрчимжих эрсдэл үүсэж болзошгүй.	Дунд	Дунд

1.2. Инфляцын гүйцэтгэл

Инфляц III улиралд улсын хэмжээнд 6.2 хувьд хүрч, өмнөх улирлаас 0.5 нэгж хувиар нэмэгдлээ. Үүнд, хүнснээс бусад бүлэг голлон нөлөөлсөн байна. Тодруулбал, III улиралд хүнсний бус бүлэг дэх 1) үйлчилгээний үнэ, тэр дундаа боловсролын үйлчилгээ, орон сууцны түрээсийн үнэ нэмэгдсэний зэрэгцээ 2) импортын хувцас, бөс барааны үнийн өсөлт эрчимжив.

Зураг 1.2 Инфляц




Эх сурвалж: УСХ

Сүүлийн байдлаарх инфляцын төлөвийг авч үзвэл инфляц алгуур нэмэгдэж 10 дугаар сард улсын хэмжээнд 7.0 хувьд хүрлээ (Зураг 1.2). Дараах хэсэгт дэлгэрэнгүй тайлбарлавал:

Хүнсний үнийн жилийн өсөлт тайлант сард 7.7 хувьд хүрч, инфляцад эзлэх хувь өмнөх улирлаас 0.2 нэгж хувиар нэмэгдэж, 2.2 хувь боллоо. Үүнд, дотоодын мах, махан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны намар эрчтэй хямдарсан суурь үе голлон нөлөөлсөн байна. Харин махнаас бусад хүнсний бүлгийн инфляцад эзлэх хувь буурав. Тухайлбал, өнгөрсөн оны мөн үед сүүний гарц багассан болон үр тарианы чанар муу байсны улмаас сүү, гурил, тэдгээртэй холбоотой бараа бүтээгдэхүүний үнэ өсөж байсан бол энэ онд харьцангуй тогтвортой байна.

Үйлчилгээний бүлгийн инфляцад эзлэх хувь нэмэгдсэн хэвээр байна. Тайлант сар буюу 10 дугаар сард үйлчилгээний бүлгийн үнийн өсөлт III улирлаас 1.2 нэгж хувиар нэмэгдэж, 9.6 хувьд хүрэв (Зураг 1.3). Ийнхүү үйлчилгээний инфляц эрчимжихэд боловсролын үйлчилгээ, орон сууцны түрээс, шүдний эмчийн үзлэгийн төлбөр зэрэг голлон нөлөөлжээ. Эдийн засгийн идэвхжил, төсвийн өндөр зардал, цалингийн эрчтэй өсөлт зэрэг нь эрэлтийн шалтгаантай инфляцыг өдөөж байна.


Зураг 1.3 Үйлчилгээний инфляц, бүрэлдэхүүн



Эх сурвалж: УСХ

Импортын барааны үнийн жилийн өсөлт тайлант сард 4.9 хувьд хүрч нэмэгдсэн байна. Үүнд, хувцас, бөс барааны үнэ сүүлийн 3 сар дараалан өссөн нь голлон нөлөөлөв. Харин импортын хүнс, шатахууны үнэ сүүлийн саруудад тогтвортой хэвээр байна.


Зураг 1.4 Инфляцад нөлөөлж буй хүчин зүйлс³



Эх сурвалж: УСХ, Монголбанк

³ Нийт сагсны 46 хувь нь импортын бараа бүтээгдэхүүнээс бүрддэг. Үүний 44.8 хувийг БНХАУ, 21.7 хувийг ОХУ, 17.1 хувийг Япон, 7.6 хувийг БНСУ бүрдүүлж байна. ОХУ-ын бараа, бүтээгдэхүүний 50 хувийг шатахуун, Японы бараа, бүтээгдэхүүний 97 хувийг автомашин бүрдүүлж байна.

Зураг 1.5 Жилийн инфляц, бүрэлдэхүүнээр⁴



Эх сурвалж: УСХ, Монголбанк

1.3. Төсөөллийн зөрүү

Инфляц 2024 оны III улиралд төсөөллөөс дээгүүр байв. Тодруулбал, хүнсний инфляц төсөөллийн орчимд гарсан ч дотоод эрэлт, цалингийн өсөлтийн нөлөөгөөр үйлчилгээ, импортын барааны үнэ сүүлийн саруудад өмнөх төсөөллөөс өндрөөр өсөж, инфляцыг нэмэгдүүллээ. Болзошгүй зуд, цаг агаарын өөрчлөлт болон төсөв, гадаад орчны эрсдэл зэргээс шалтгаалан төсөөллийн тодорхой бус байдал нэмэгдэж байна.

⁴ Үйлчилгээ, төрийн зохицуулалтай үйлчилгээний бүлгийг нэгтгэж “Үйлчилгээ”, хатуу түлш, бусад дотоодын бараа бүлгийг нэгтгэж “Дотоодын бараа”, мах, махнаас бусад дотоодын хүнсний бүлгийг нэгтгэж “Дотоодын хүнс”-ний бүлэг болгов.

2. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

2.1. Эдийн засгийн өсөлтийн цаашдын төлөв

Төсөөлөлд ашигласан гол таамаглалт нөхцөлүүд:

- Бодлогын хүүг 2024 оны 4 дүгээр улирал, 2025 оны 1 дүгээр улиралд 10 хувьд хэвээр хадгалах;
- Төсвийн зардал батлагдсан дүнгээс 1.9 их наяд төгрөгөөр буурах;
- Нүүрсний экспортын биет хэмжээ 2024-26 онд өмнөх төсөөллөөс 4 сая тонноор нэмэгдэх;
- Хөрөнгийн орох урсгал 2024-2026 онд өмнөх төсөөллөөс харгалзан 252, 270, 358 сая ам.доллароор нэмэгдэх.

Эдийн засгийн өсөлт 2024 онд 5.2 хувь, 2025 онд 7.5 хувь, 2026 онд 4.7 хувьд хүрэх тооцоололтой байна (Хүснэгт 2.1). Эдийн засгийн өсөлтийн төсөөллийг нийлүүлэлт болон эрэлт талаас доор тайлбарлалаа.

Хүснэгт 2.1 Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл⁵

	2023	2024*	2025*	2026*
		Төсөөлөл		
ДНБ-ий өсөлт	7.4	5.2 [4.8-6.0]	7.5 [5.4-9.7]	4.7 [2.0-7.4]
Уул уурхай	23.4	13.3 [12.9-14.1]	21.4 [19.3-23.6]	4.9 [2.3-7.6]
Уул уурхайн бус	5.4	4.0 [3.6-4.8]	5.3 [3.2-7.5]	4.6 [2.0-7.3]

Эх сурвалж: Монголбанк


Нийт нийлүүлэлт

Эдийн засгийн өсөлт энэ онд өмнөх төсөөллөөс бага зэрэг буурахаар байна. Тодруулбал, нүүрсний олборлолт өмнөх төсөөллөөс нэмэгдэж байгаа ч алтны үйлдвэрлэл өмнөхөөс буурч, уул уурхайн салбарын өсөлт өмнөхөөс саарах, барилга, боловсруулах салбарын үйлдвэрлэл

удаашрах зэрэг нь өсөлтийн төсөөлөл буурах гол шалтгаан боллоо.

Ирэх онд эдийн засгийн өсөлт өмнөх төсөөллөөс бага зэрэг нэмэгдэхээр байна. Үүнд, нүүрсний экспорт өмнөх төсөөллөөс нэмэгдэж, уул уурхайн салбарын өсөлт сайжрах нь гол нөлөөг үзүүлнэ. Уул уурхайн бус салбарын хувьд өмнөх төсөөллийн орчимд хадгалагдахаар байна (Зураг 2.1).

Зураг 2.1 4 улирлын нийлбэр ДНБ-ий жилийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк

Уул уурхай: Уул уурхайн салбарын үйлдвэрлэл 3-р улиралд хүлээлтээс бага гарсан хэдий ч оны эцэст эргэн сэргэснээр 2024 онд тус салбар 13.3 хувиар өсөх төлөвтэй байна. Дунд хугацаанд Оюу толгойн үйлдвэрлэл эрчимжихийн зэрэгцээ нүүрсний олборлолт энэ оны өндөр түвшинд хадгалагдаж, уул уурхайн салбарын өсөлтийг тэтгэх хүлээлт хэвээр байна.

Уул уурхайн бус салбар: Нүүрсний экспорт нэмэгдэж, тээвэр, худалдааны салбарын өсөлт энэ онд өндөр хэвээр байх бол дотоод эдийн засгийн идэвхжлийг дагаад үйлчилгээний салбар сайжрах, импортын өндөр өсөлттэй уялдан бүтээгдэхүүний цэвэр татварын орлого эрчимжиж, уул уурхайн бус салбарын өсөлтийг тэтгэхээр

⁵ 30 хувийн магадлалтай итгэх интервал

байна. Харин барилга, боловсруулах салбарын үйлдвэрлэл хүлээлтээс бага гарч, удаашрах төлөвтэй боллоо. Ийнхүү уул уурхайн бус салбарын өсөлт энэ онд 4 хувь байх ба үүнээс хөдөө аж ахуйн салбарыг хасаж тооцвол өсөлт 9 орчим хувь байхаар байна.

Ирэх онд хөдөө аж ахуйн салбар зудын хүндрэлээс сэргэх, төсвийн төлөв сулрах, хөрөнгө оруулалтууд нэмэгдэх, Бөөрөлжүүтийн цахилгаан станц ашиглалтанд орох зэрэгтэй холбоотойгоор эрчим хүчний үйлдвэрлэл тэлэх зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр уул уурхайн бус салбарын үйлдвэрлэл 5.3 хувиар өсөх тооцоололтой. Харин 2026 оноос төсвийн төлөв чангарах, хөрөнгө оруулалтууд буурах, худалдааны нөхцөл муудаж, гадаад эрэлт буурах зэрэг нь өсөлтийн төлөвийг сааруулна гэж үзлээ.

Нийт эрэлт

Нүүрснээс бусад алт, зэс, газрын тос зэрэг түүхий эдийн экспортын биет хэмжээ өмнөх төсөөллөөс буурсан нь энэ оны эдийн засгийн өсөлтийн төсөөллийг өмнөхөөс бууруулах гол шалтгаан боллоо (Хүснэгт 2.2).

Дотоод эрэлт: Энэ онд дотоод эрэлт талаас өрхийн хэрэглээ өндөр түвшинд хадгалагдах, төрийн байгууллагын хэрэглээ 30 гаруй хувьд хүрч өсөхөөр байгаа нь нийт эрэлтийг тэтгэхээр байна. Түүнчлэн барилгын материалын дуусаагүй үйлдвэрлэл, нүүрсний овоолго нэмэгдсэнээс шалтгаалан материаллаг эргэлтийн хөрөнгийн өсөлт өмнөх оноос сайжирсан нь дотоод эрэлтэд эерэг нөлөөтэй байна.

Ирэх онд төрийн байгууллагын хэрэглээ, хөрөнгө оруулалт тэлэх, эдийн засгийн идэвхжил нэмэгдэх нөлөөгөөр дотоод эрэлт

нийт эрэлтийн өсөлтөд голлох эерэг нөлөөг үзүүлэхээр байна.

Цэвэр экспорт: Энэ онд бараа, үйлчилгээний импорт өндөр байгаагаас шалтгаалан цэвэр экспорт нийт эрэлтийн өсөлтөд 16.2 хувийн сөрөг нөлөө үзүүлэхээр байна. Тодруулбал, нүүрсний экспорт нэмэгдсэнээс шалтгаалан хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн болон дизель түлшний импорт нэмэгдэхээр байна. Түүнчлэн, эдийн засгийн идэвхжилийг дагаад хэрэглээний бүтээгдэхүүний импорт үргэлжлэн тэлэхээр тооцов. Нөгөө талаас, нүүрснээс бусад түүхий эдийн экспорт 3-р улиралд бага гарч, энэ оны экспортын өсөлтийн төсөөлөл буурлаа. Ийнхүү импортын өсөлт экспортын өсөлтөөс өндөр хадгалагдах нь нийт эрэлтийг бууруулах нөлөө үзүүлнэ.

Ирэх онд зэс, алт, түүхий нефтийн экспорт нэмэгдэхийн зэрэгцээ нүүрс, төмрийн хүдрийн экспорт өндөр түвшинд хадгалагдаж, нийт эрэлтэд цэвэр экспортын үзүүлэх нөлөө өмнөх оноос сайжрах хүлээлттэй байна.

Хүснэгт 2.2 Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл

	2023	2024*	2025*
		Төсөөлөл	
ДНБ-ий өсөлт	7.2	5.2	7.5
Дотоод эрэлт	5.4	21.4	8.0
Цэвэр экспорт	1.8	-16.2	-0.5

Эх сурвалж: Монголбанк

Эдийн засгийн цаашдын төлөвт нөлөөлж болзошгүй тодорхой бус байдал


Эрсдэл, тодорхой бус байдал	Магадлал	Нөлөө
БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарт хямрал үргэлжлэхийн зэрэгцээ АНУ-аас авч хэрэгжүүлэх тарифын бодлогын нөлөөгөөр БНХАУ-ын өсөлтийн төлөв саарч болзошгүй байна. Энэ нь манай улсын гадаад эрэлт, экспортын бүтээгдэхүүний үнэд сөргөөр нөлөөлж, гадаад валютын орох урсгалыг муутгах эрсдэлтэй. Энэ тохиолдолд төсвийн орлого төлөвлөгөөнөөс буурах, эдийн засгийн өсөлт муудах эрсдэлтэй.	Дунд	Өндөр (сөрөг)
Төсвийн тэлэх бодлого ирэх онд үргэлжлэхээр байгаа нь төлбөрийн тэнцэлд томоохон дарамт учруулж болзошгүй байна. Ялангуяа, Монгол Улсын ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 14 мега төсөл хэрэгжүүлэхээр тусгаснаас зөвхөн 4 төсөл нь төсөвт туссан бөгөөд бусад төслийн санхүүжилт хэрхэн шийдвэрлэгдэх нь тодорхойгүй байна. Эдгээр томоохон төслүүдийг дотоод эх үүсвэрээс санхүүжүүлэх тохиолдолд төлбөрийн тэнцлийн алдагдал огцом тэлж, эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрт байдал алдагдаж, өсөлтийг төлөв муудах эрсдэлтэй.	Өндөр	Өндөр (сөрөг)
Төсвийн хэт тэлэлт нь хувийн секторын өргөжих боломжийг хязгаарлаж, хөдөлмөрийн зах зээлд бүтээмжийн өсөлт бий болохгүй байх, хувийн хөрөнгө оруулалт буурах зэрэг эрсдэлийг дагуулж болзошгүй байна. Энэ нь дунд хугацаанд эдийн засгийн тогтвортой, тэнцвэртэй өсөлтийг хязгаарлана	Дунд	Өндөр (сөрөг)

Олон улс хоорондын геополитикийн зөрчил үргэлжилсэн хэвээр байна. Цаашлаад хоёр том гүрний худалдааны дайны эрсдэлтэй холбоотойгоор олон улсын талцал, хуваагдал улам гүнзгийрэх эрсдэлтэйг шинжээчид анхааруулж байна.	Бага	Дунд (сөрөг)
---	------	--------------

Потенциал үйлдвэрлэл⁶

Цар тахал, геополитикийн хүндрэлээс эдийн засаг сэргэж, потенциал үйлдвэрлэлийн өсөлт 2022 оноос алгуур тогтвортой нэмэгдэж эхэлсэн бөгөөд сүүлийн улирлуудад потенциал өсөлт тогтворжих хандлагатай байна. Тодруулбал, олон хувьсагчийн Калман фильтр, нэг хувьсагчийн НР фильтр, үйлдвэрлэлийн функц зэрэг ялгаатай аргачлалуудаар тооцсон потенциал үйлдвэрлэлийн өсөлт сүүлийн улирлуудад 5-6 хувийн орчимд тогтвортой хадгалагдаж байна (Зураг 2.2).

Зураг 2.2 Потенциал үйлдвэрлэлийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк

Үйлдвэрлэлийн функцын аргачлалаар тооцсон потенциал үйлдвэрлэлийн өсөлтийн тал орчим хувийг капитал хуримтлал, үлдсэн хэсгийг хөдөлмөрийн орц бүрдүүлж байгаа бол бүтээмжийн өсөлт сөрөг нөлөөтэй байна.

⁶ Үйлдвэрлэлийн хүчин зүйлс хэвийн ашиглалттай байх үеийн үйлдвэрлэл. Потенциал үйлдвэрлэл нь статистик


мэдээллээс шууд тооцогдохгүй тул эдийн засгийн тэнцвэрийн шинжилгээнээс тооцон гаргадаг.

Үйлдвэрлэлийн зөрүү⁷

Уул уурхайн салбар сэргэж, дотоод эдийн засгийн идэвхжил нэмэгдсэнээр нийт үйлдвэрлэлийн зөрүү 2023 оны сүүлийн хагаст эерэг түвшинд хүрэв. Харин 2024 оны эхнээс алгуур буурч, сүүлийн 2 улиралд сөрөг түвшинд хадгалагдлаа. Үүнд, хөдөө аж ахуй, боловсруулах зэрэг хөдөлмөр ихээр шингээдэг салбарын үйлдвэрлэл саарснаас шалтгаалан уул уурхайн бус үйлдвэрлэлийн зөрүү буурсан нь голлон нөлөөлөв.

Уул уурхайн үйлдвэрлэл 2023 оноос сэргэж, тайлант улирал хүртэлх 7 улирлын хугацаанд потенциал түвшнийхээ орчимд хэлбэлзэж байна (Зураг 2.3).

Зураг 2.3 Үйлдвэрлэлийн зөрүү⁸



Эх сурвалж: Монголбанк

2.2. Эдийн засгийн өсөлтийн гүйцэтгэл

Гуравдугаар улирлын эдийн засгийн өсөлтийг тоймлон авч үзвэл:

- Уул уурхайн салбарын өсөлт саарч;
- Боловсруулах салбар огцом унав;
- Худалдаа, бусад үйлчилгээний салбарын идэвхжил өндөр байв.


Нийт нийлүүлэлт

Нийт үйлдвэрлэл тайлант улиралд 3.9 хувь, эхний гурван улирлын нийлбэр дүнгээр 5.0 хувиар өслөө. Уул уурхайн олборлолт,

⁷ Үйлдвэрлэлийн зөрүү нь потенциал үйлдвэрлэл болон бодит ДНБ-ий зөрүүгээр тодорхойлогдоно.

үйлчилгээний салбарын идэвхжил, үүнийг дагасан татварын өндөр орлого өсөлтийг голлон бүрдүүлж байна.

Зураг 2.4 Нийт үйлдвэрлэлийн өсөлт, улирлаар



* - Худалдаа, мэдээлэл холбоо, бусад үйлчилгээ

Эх сурвалж: УСХ

Нийт үйлдвэрлэлийн III улирлын өсөлтийг салбаруудаар авч үзвэл (Зураг 2.4):

Үйлчилгээний салбарын⁹ идэвхжил оны турш нэмэгдэж (Зураг 2.5), тайлант улиралд жилийн 10.7 хувьд хүрч, өсөлтөд 4.3 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлэв. Дэлгэрүүлбэл, зээлийн өндөр өсөлт нь санхүүгийн салбарыг дэмжиж байгаа бол хэрэглээг даган худалдааны салбарын орлого өндөр байна.

Зураг 2.5 Үйлчилгээний салбарын идэвхжил нэмэгдэв




Эх сурвалж: УСХ, Монголбанк

⁸ Макро эдийн засгийн загварт суурилсан тооцоолол.

⁹ Худалдаа, мэдээлэл холбоо, бусад үйлчилгээ

Уул уурхайн салбарын өсөлт саарч, III улиралд 5.6 хувь болов. Тодруулбал, өнгөрсөн оноос эхлэн уул уурхайн салбарын өсөлтийг голлон бүрдүүлж байсан нүүрс олборлолтын нөлөө буурлаа. Мөн алт, газрын тосны үйлдвэрлэл оны турш буурсан байна (Зураг 2.6).

Зураг 2.6 Уул уурхайн салбарын өсөлт, улирлаар




Оны эхний хагаст 7.9 хувиар тэлээд байсан аж үйлдвэр, барилгын салбар III улиралд 5.5 хувиар уналаа. Тухайлбал, хөнгөн үйлдвэрлэл буюу хүнс (мах боловсруулах, үр тариа), ээрэх нэхэх, хувцас үйлдвэрлэл зэрэг салбаруудын үйлдвэрлэл буурснаар боловсруулах салбар III улиралд жилийн 8.7 хувиар огцом агшсан нь голлон нөлөөлөв.

Нийт эрэлт

Нийт эрэлт 2024 оны эхний 3 улиралд 4.9 хувь, 3-р улиралд 3.5 хувиар өслөө. Энэхүү өсөлтийг 1) өрхийн хэрэглээ, 2) төрийн байгууллагын хэрэглээ, 3) хөрөнгийн нийт хуримтлал бүрдүүлэв (Зураг 2.7).


Зураг 2.7 Өрхийн хэрэглээ болон засгийн газрын хэрэглээ нийт эрэлтийг тэлж байна



Өрхийн хэрэглээ 2024 оны 3-р улиралд 9.7 хувиар тэлж, нийт өсөлтийн 6.5 нэгж хувийг бүрдүүлсэн байна. Өрхийн бодит орлого өндөр өсөж байгаа нь өрхийн хэрэглээг дэмжиж байна (Зураг 2.8).

Өрхийн хэрэглээг бүтцээр нь задалбал хүнсний хэрэглээ төдийлөн нэмэгдээгүй, харин хүнсний бус хэрэглээ өссөн хэвээр байна. Хүнсний бус хэрэглээ 2024 оны 3-р улиралд улиралд 28.1 орчим хувиар өсөхөд тээврийн хэрэгсэл, хувцас, бөс бараа, орон сууцны хэрэглээ голчлон нөлөөлжээ.

Зураг 2.8 Өрхийн хэрэглээний өсөлт өндөр байна




Төсвийн тэлэлттэй уялдан төрийн байгууллагын хэрэглээ бодит дүнгээр 2024 3-р улиралд өмнөх жилээс 18.9 хувиар нэмэгдэж, тайлант улирлын өсөлтийн 3.0

нэгж хувийг бүрдүүлэв. Тухайлбал, бараа үйлчилгээний зардал тайлант улиралд бодит дүнгээр 31.6 орчим хувиар нэмэгдсэн байна.

Хөрөнгийн нийт хуримтлал 2024 оны 3-р улиралд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 37.7 хувиар өсөж, нийт эрэлтийн өсөлтөд 13.1 нэгж хувийн эерэг нөлөө үзүүллээ. Үүнийг задалж тайлбарлавал үндсэн хөрөнгийн хуримтлалд малын хорогдол буурах нөлөөг үзүүлж буй ч машин тоног төхөөрөмж, бусад барилга байгууламж өсөлттэй байгаа тул 3-р улиралд нийт эрэлтэд 5.6 нэгж хувийн нэмэгдүүлэх нөлөөг үзүүлсэн байна. Мөн нийт бараа материал, уул уурхайн бүтээгдэхүүний үлдэгдэл (овоолго) их байгаа нь материаллаг эргэлтийн хөрөнгийг дэмжиж, нийт өсөлтөд 7.5 нэгж хувийн эерэг нөлөөг үзүүлэв.

Цэвэр экспорт 2024 оны 3-р улиралд нийт өсөлтөд 19.0 хувийн сөрөг нөлөөг үзүүлсэн байна. Нүүрсний экспортын биет хэмжээ тайлант хугацаанд 19.7 сая тонн болж өссөн (Зураг 2.9) хэдий ч зэс, газрын тосны экспортын биет хэмжээ өмнөх оны мөн үеэс багассанаас шалтгаалан нийт экспорт эрэлтэд 3.0 сөрөг нөлөөг үзүүлсэн байна. Түүнчлэн, хэрэглээ, хөрөнгө оруулалтын импорт эрчтэй тэлж нийт эрэлтийн 16.0 нэгж хувийн сөрөг нөлөөг тайлбарлав.

Зураг 2.9 Нүүрсний экспорт нэмэгдэж байна



Эх сурвалж: ГЕГ

3. ДОТООД ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

3.1. Хөдөлмөрийн зах зээл

Хөдөлмөрийн насны хүн амын тоо тайлант улиралд 2'298 мянгад хүрлээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ажиллах хүч өсөж, ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо буурсан байна (Хүснэгт 3.1).


Хүснэгт 3.1 Хөдөлмөрийн насны хүн амын шилжилт хөдөлгөөн

мянган хүн	2019Q3	2023Q3	2024Q2	2024Q3
Хөдөлмөрийн насны хүн ам	2133.5	2272.5	2297.9	2298.0
Ажиллах хүч	1282.5	1400.1	1429.4	1448.4
Ажиллагчид	1155.9	1326.2	1347.1	1360.3
Бүрэн хөдөлмөр эрхлэлт	1145.1	1318.9	1339.9	1358.6
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөд.эрхлэлт	10.9	7.3	7.2	1.7
Ажилгүй хүн	126.6	73.9	82.3	88.1
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	851.0	872.4	868.5	849.6
Боломжит ажиллах хүч	51.4	43.6	27.8	20.6
Бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам	799.6	828.8	840.7	829.1

Эх сурвалж: УХС

Ажилгүй хүмүүсийн тоо өмнөх улирлаас 7 хувиар, өмнөх оны мөн үеэс 19.2 хувиар өсөж 88.1 мянган хүнд хүрэв. Ийнхүү ажилгүйдлийн түвшин тайлант улиралд 6.1 хувьд хүрч өсжээ (Зураг 3.2).


Зураг 3.1 Хөдөлмөрийн насны хүн амын жилийн өөрчлөлт, бүрэлдэхүүнээр



Эх сурвалж: УХС

Ажиллах хүчний оролцооны түвшин 2023 оноос хойш алгуур нэмэгдэж байна. Тайлант улиралд цар тахлаас хойших хамгийн дээд түвшинд буюу 63 хувьд хүрчээ. Энэ нь өмнөх улирлаас 1.3 нэгж хувиар, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.3 нэгж хувиар өссөн үзүүлэлт юм. Ажиллах хүч өсөхөд бүрэн хөдөлмөр эрхлэлт өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг 3.2 Хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлтүүд




Эх сурвалж: УСХ

Ажил эрхлэлт, нийгмийн даатгал

Нийт ажиллагчдын тоо тайлант улиралд өмнөх оны мөн үеэс 34 мянган (2.6%) хүнээр өссөн байна. Тодруулбал, уул уурхай, барилга, худалдаа, тээвэр, бусад үйлчилгээний салбарт ажиллагчдын тоо нэмэгдэж, харин хөдөө аж ахуй болон боловсруулах салбарт ажиллагчид буурчээ (Зураг 3.3).

Ажил эрхлэлтийн түвшин нэмэгдэхийн зэрэгцээ нийгмийн даатгалд хамрагдагчдын тоо нэмэгдэж байна. 2024 оны 9-р сарын байдлаар нийгмийн даатгалд хамрагдагчдын тоо өмнөх оны мөн үеэс 17 хувиар нэмэгдээд байна. Үүнд, албан журмаар даатгуулагчдын тоо 300 орчим мянган хүнээр өссөн бол сайн дураар даатгуулагчдын тоо 127 орчим мянган хүнээр хувиар буурав.

Зураг 3.3 Ажиллагчдын тооны жилийн өөрчлөлт, салбараар



Эх сурвалж: УСХ

Цалин, өрхийн орлого

Улсын нэрлэсэн дундаж цалин 2024 оны 3-р улиралд жилийн 23.4 хувиар өссөн бол медиан цалин 30.1 хувиар өслөө. Ингэснээр дундаж цалин 2480 мянган төгрөг, медиан цалин 2024 мянган төгрөгтэй тус тус тэнцэв. Цалин нэмэгдсэн нь өрхийн орлогыг дэмжиж, хэрэглээг тэтгэж байна. Сүүлийн улирлуудад нэрлэсэн цалин өндөр хувиар өссөний зэрэгцээ инфляцын түвшин тогтвортой байгаагаас бодит цалингийн өсөлт эрчтэй байна. Тухайлбал, тайлант улиралд бодит цалин жилийн 16.3 хувиар нэмэгджээ. Энэ өсөлт нь өрхийн орлого, амьжиргааны түвшинг сайжруулах нөлөөтэй ч бүтээмжээс давсан цалингийн өсөлт нь үйлдвэрлэлийн зардал, эрэлтээр дамжин үнийн дарамтыг нэмэгдүүлж болзошгүй юм (Зураг 3.4).

Зураг 3.4 Цалингийн болон өрхийн орлогын өсөлт




Эх сурвалж: УСХ

Эдийн засгийн голлох салбаруудаар авч үзвэл боловсрол (36%), төрийн удирдлага (31%), эрчим хүч (31%), санхүү ба даатгал (29%), мэдээлэл холбоо (26%), тээвэр ба агуулах (25%-н салбарт ажиллагчдын дундаж нэрлэсэн цалин хамгийн өндөр өсжээ. Харин уул уурхай (7%), барилга (19%), худалдаа (22%), боловсруулах (21%) салбарын ажиллагчдын дундаж цалингийн өсөлт бага байна.

Нэгж хөдөлмөрийн зардал

Нэгж хөдөлмөрийн зардал¹⁰ сүүлийн хоёр жил хагасын хугацаанд өндөр өсөлттэй байсаар байна. Тодруулбал, цалингийн өсөлт бүтээмжийн өсөлтөөс үлэмж өндөр байгаа нь цаашид үйлдвэрлэлийн зардлыг нэмэгдүүлж, улмаар бүтээгдэхүүний үнийн өсөлтөд нөлөөлөх эрсдэлтэй юм (Зураг 3.5).

Зураг 3.5 Нэгж хөдөлмөрийн дундаж зардлын жилийн өөрчлөлт, бүрэлдэхүүнээр



Эх сурвалж: УСХ

3.2. Мөнгө, санхүүгийн зах зээл


3.2.1. Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт саарсан бол зээлийн өсөлт үргэлжлэн эрчимжлээ.

Энэ оны 6 дугаар сард 31.9 хувьд хүрч эрчимжээд байсан мөнгөний нийлүүлэлтийн өсөлт сүүлийн 4 сарын турш алгуур саарч, 10 дугаар сард 25.1 хувьд хүрлээ. Үүнд, төлбөрийн тэнцлийн алдагдалтай холбоотойгоор ГЦА-ын өсөлт саарч, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд үзүүлэх нөлөө буурсан нь голлон нөлөөлөв (Зураг 3.6). Нөгөө талаас зээлийн өсөлт үргэлжлэн эрчимжиж, M2 мөнгөний өсөлтөд үзүүлэх нөлөө нь нэмэгдсээр байна. Нэгдсэн төсвийн тэнцэл 2024 оны эхний 10 сарын байдлаар 1.5 их наяд төгрөгийн ашигтай байгаагаас ЗГЦЗ мөнгөний

нийлүүлэлтийн өсөлтөд сөрөг нөлөөтэй хэвээр байна.


Зураг 3.6 Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, актив тал



Эх сурвалж: Монголбанк

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд зээл 27.1 нэгж хувь, ГЦА 7.2 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлсэн бол ЗГЦЗ 5.3 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлээ.

Зураг 3.7 Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, пассив тал




Эх сурвалж: Монголбанк

Эх үүсвэр талаас мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг төгрөгийн эх үүсвэр голлон бүрдүүлсэн хэвээр байна. Тухайлбал, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 16.1 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 7.8 нэгж хувийг төгрөгийн харилцах бүрдүүлэв. Харин гадаад валютын хадгаламж -1.3 нэгж хувь, гадаад валютын харилцах 2.2 нэгж хувийн нөлөөг тус тус үзүүлээ.

¹⁰ Нэгж ДНБ-д ногдох дундаж хөдөлмөрийн өртөг буюу цалин.


Зураг 3.8 Банкуудын зээл болон эх үүсвэрийн долларжилт



Эх сурвалж: Монголбанк

Улмаар банкны системийн эх үүсвэрийн долларжилт 2024 оны 10 дугаар сард 25.1 хувьд хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 5.3 нэгж хувиар буурсан дүн юм. Ханшийн нөлөөг хасаж тооцвол эх үүсвэрийн долларжилт 20.7 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 4.4 нэгж хувиар буурсан байна (Зураг 3.8).

Зураг 3.9 Арилжааны банкуудын зээлийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн



Эх сурвалж: Монголбанк

Банкны системийн зээлийн жилийн өсөлт үргэлжлэн эрчимжиж, 10 дугаар сард 34.6 хувьд хүрлээ (Зураг 3.9). Зээлийн зориулалтаар нь харвал, энэ онд санхүүжилт өндөр байгаагаас ипотекийн зээлийн өсөлт

өндөр түвшинд хадгалагдсаар байна¹¹. Түүнчлэн, өнгөрсөн онд эрчтэй өсөөд байсан хэрэглээ, хадгаламж барьцаалсан зээлийн өсөлт сүүлийн саруудад 37-39 хувийн орчимд тогтвортой байна. Харин бизнесийн зээлийн өсөлт 31.3 хувьд хүрч эрчимжсэн бөгөөд эдийн засгийн салбараар авч үзвэл, худалдаа, үйлчилгээ, уул уурхай, боловсруулах, хөдөө аж ахуйн салбарын зээл голлон өсөж, бизнесийн зээлийн өсөлтийг тэтгэлээ¹².

Валютын төрлөөр нь авч үзвэл, банкны системийн төгрөгийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 34.9 хувиар, гадаад валютын зээлийн үлдэгдэл 30.7 хувиар өсөв. Ийнхүү төгрөгийн зээл гадаад валютын зээлээс илүү өндрөөр өссөнөөр зээлийн долларжилт өмнөх оны мөн үеэс буурч, тайлант сард 5.5 нэгж хувьд хүрлээ (Зураг 3.8).


Банкны системийн чанаргүй болон анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс буурснаас гадна нийт зээлийн үлдэгдэл нэмэгдэж, чанаргүй болон анхаарал хандуулах зээлийн нийт зээлд эзлэх хувь буурлаа. Тодруулбал, 2024 оны 10 дугаар сард чанаргүй зээлийн үлдэгдэл 2.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 123 тэрбум төгрөг буюу 5.6 хувиар буурав¹³. Үүнд, үл хөдлөх, уул уурхайн салбарын чанаргүй зээл голлон буурчээ. Улмаар чанаргүй зээлийн үлдэгдэл нийт зээлийн багцын 5.8 хувийг бүрдүүлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.5 нэгж хувиар бага дүн юм (Зураг 3.10).

¹¹ 2024 оны 10 дугаар сард 25.1 хувьд хүрэв.

¹² Дээрх 5 салбарын зээлийн өсөлт бизнесийн зээлийн өсөлтийн 86 хувийг тайлбарлаж байна.

¹³ Түүнчлэн, 2024 оны 9 дүгээр сард чанаргүй зээлийн үлдэгдэл нийт зээлд эзлэх хувь 5.7 хувьд хүрсэн нь 2015 оноос хойших хамгийн бага дүн болов


Зураг 3.10 Банкны системийн чанаргүй зээлийн жилийн өсөлт, эдийн засгийн салбаруудаар



Эх сурвалж: Монголбанк

Банкны системийн анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл 2024 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс 99 тэрбум төгрөг буюу 7.2 хувиар буурч, 1.3 их наяд төгрөгт хүрээд байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал худалдаа, барилга, уул уурхайн салбарын анхаарал хандуулах зээл голлон буурсан бол нөгөө талаас хэрэглээ, хадгаламж барьцаалсан анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл өссөн байна. Улмаар анхаарал хандуулах зээл нийт зээлийн багцын 3.7 хувийг бүрдүүлж байгаа нь 2014 оноос хойших хамгийн бага дүн юм.

Зураг 3.11 Банкны системийн анхаарал хандуулах зээлийн жилийн өсөлт, эдийн засгийн салбаруудаар



Эх сурвалж: Монголбанк

3.2.2. Хүү

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2024 оны 9 дүгээр сарын хурлаар бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж 10 хувьд хүргэх, 12 дугаар сарын хурлаар бодлогын хүүг хэвээр хадгалах шийдвэрийг тус тус гаргалаа. Бодлогын хүү буурсантай холбоотойгоор банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү 2024 оны 10 дугаар сард өмнөх улирлаас¹⁴ 0.9 нэгж хувиар буурч 10.1 хувьд хүрлээ. Тодруулбал, ТБҮЦ барьцаалсан репо хэлцлийн хүү 1.0 нэгж хувиар буурч 10.0 хувьд, ТБҮЦ-ны шууд хэлцлийн хүү 1.0 нэгж хувиар буурч 10.0 хувьд, банк хоорондын захын хадгаламжийн хүү 0.5 нэгж хувиар буурч 10.5 хувьд, банк хоорондын захын овернайт зээлийн хүү 0.9 нэгж хувиар буурч 10.0 хувьд тус тус хүрсэн байна (Зураг 3.12).

Зураг 3.12 БХЗ-ын хэлцлийн хүү, хувь



Эх сурвалж: Монголбанк

Банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү ийнхүү буурсан хэдий ч банкнуудын шинээр татсан төгрөгийн хадгаламж болон шинээр олгосон төгрөгийн зээлийн хүү нэмэгдлээ. Тухайлбал, банкнуудын шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүү энэ оны 10 дугаар сард өмнөх улирлаас 0.4 нэгж хувиар өсөж 12.1 хувьд хүрсэн бол шинээр олгосон төгрөгийн зээлийн хүү 0.7 нэгж хувиар өсөж 16.7 хувьд тус тус хүрлээ.

¹⁴ 2024 оны 6 дугаар сартай харьцуулахад

Үүнээс хөнгөлөлттэй зээлийг¹⁵ хасаж тооцсон шинээр олгосон төгрөгийн зээлийн хүү тайлант сард 17.0 хувьд буюу өмнөх улирлын орчимд тогтвортой хадгалагдлаа. Улмаар зээл, хадгаламжийн хүүний зөрүү өмнөх улирлаас 0.2 нэгж хувиар нэмэгдэж, тайлант сард 4.6 хувьд хүрлээ (Зураг 3.13).


Зураг 3.13 Шинээр олгосон зээлийн болон шинээр татсан хадгаламжийн хүү, төгрөг



* Нийт зээлийн хүүнээс тооцсон
Эх сурвалж: Монголбанк

Шинээр олгосон гадаад валютын зээлийн хүү өмнөх улирлаас буурсан бол шинээр татсан гадаад валютын хадгаламжийн хүү өслөө. Тодруулбал, шинээр олгосон гадаад валютын зээлийн хүү энэ оны 10 дугаар сард 9.1 хувьд хүрч өмнөх улирлаас 1.9 нэгж хувиар буурсан бол шинээр татсан гадаад валютын хадгаламжийн хүү 4.9 хувьд хүрч өмнөх улирлаас 2.0 нэгж хувиар өссөн байна. Улмаар гадаад валютын зээл, хадгаламжийн хүүний зөрүү өмнөх улирлаас 3.9 нэгж хувиар буурч 4.2 хувьд хүрлээ (Зураг 3.14).

Зураг 3.14. Шинээр олгосон зээлийн болон шинээр татсан хадгаламжийн хүү, гадаад валют



Эх сурвалж: Монголбанк

3.2.3 Валютын ханш


Төгрөгийн ам.доллартой харьцах ханш энэ оны 11 сарын эцсийн байдлаар 3417.8 төгрөгтэй тэнцэж, оны эхнээс 0.2 хувиар суларсан байна (Зураг 3.15).

Энэ оны 3 сараас хойш 3380 төгрөгийн орчимд тогтвортой хадгалагдаж байсан төгрөгийн ам.доллартай харьцах ханш 10 дугаар сарын эхнээс сулрах чиглэлд өөрчлөгдлөө. Үүнд, нүүрсний экспортын хэмжээ 9 дүгээр сард буурч, гадаад валютын урсгал цэвэр дүнгээр 160 сая ам.долларын алдагдалтай гарсан нь нөлөөлөв. Түүнчлэн, олон улсын зах зээлд ам.долларын индекс 10 сарын эхнээс чангарч төгрөгийн ханшид ирэх дарамтыг нэмэгдүүллээ. Харин 11 сараас нүүрсний экспорт тогтворжиж, валютын орох урсгал сайжирснаар сүүлийн сар орчмын хугацаанд төгрөгийн ханш ам.долларын эсрэг 3417 төгрөгт тогтвортой хадгалагдлаа.

¹⁵ Банкуудын зах зээлийн хүүгээс доогуур буюу Засгийн газар болон Монголбанкнаас хэрэгжүүлж буй хөтөлбөр,


төлөвлөгөөний хүрээнд хөнгөлөлттэй нөхцөлтэй олгосон зээл

Зураг 3.15 Төгрөгийн ам.доллартой харьцах ханш




Гадаад худалдааны эргэлтээр жигнэж тооцсон төгрөгийн нэрлэсэн ханш (NEER) энэ оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс 0.2 хувиар сул тогтлоо. Үүнд, төгрөгийн ханш худалдааны гол түнш БНХАУ-ын юаний эсрэг 1.5 хувиар, еврогийн эсрэг 0.9 хувиар тус тус суларсан нь гол нөлөөг үзүүллээ. Харин төгрөгийн ханш рублийн эсрэг үргэлжлэн чангарч, тайлант сард өмнөх оны мөн үеэс 6.3 хувиар чангарав. Дайнтай холбоотой өндөр зардал, инфляцын дарамт, газрын тосны экспортын орлого буурсан зэргээс шалтгаалан олон улсын зах зээлд рублийн ханш ам.долларын эсрэг хурдтай суларч байгаа нь төгрөг рублийн эсрэг ийнхүү чангарахад нөлөөлж байна.

Зураг 3.16 Төгрөгийн нэрлэсэн ба бодит үйлчилж буй ханш




Төгрөгийн нэрлэсэн ханш ийнхүү сулраад байгаа ч гадаад үнэтэй харьцуулахад дотоод үнэ нэмэгдэж, төгрөгийн бодит ханш тайлант сард өмнөх оны мөн үеэс 3.4 хувиар чанга тогтлоо.

Зураг 3.17 Төгрөгийн гадаад валютуудтай харьцах ханшийн жилийн өөрчлөлт



Төгрөгийн харьцангуй өгөөж энэ оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс 0.81 хувиар буурч, 0.27 хувьд хүрлээ (Зураг 3.18). Үүнд, төгрөгийн ханш ам.долларын эсрэг суларсан, төгрөгийн хадгаламжтай харьцуулахад гадаад валютын хадгаламжийн хүү өссөн зэрэг нь гол нөлөөг үзүүлэв. Тодруулбал, тайлант сард шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүү өмнөх оны мөн үеэс 0.15 нэгж хувиар өссөн байгаа бол гадаад валютын хадгаламжийн хүү 1.3 нэгж хувиар өссөн дүнтэй байна.

Зураг 3.18 Төгрөгийн харьцангуй өгөөж



3.2.4. Хөрөнгийн зах зээл

Тайлант улиралд орон сууцны үнэ өсөж, хөрөнгийн зах зээлийн идэвхжил нэмэгдлээ.

Орон сууцны зах зээл


Орон сууц худалдан авах, түрээслэх үнэ тайлант улиралд нэмэгдлээ. ҮСХ-ны статистик мэдээллээр орон сууцны үнэ энэ оны 3-р улиралд өмнөх оны мөн үеэс 12.2 хувиар, өмнөх улирлаас 2.7 хувиар тус тус өссөн байна. Орон сууцны насжилтаар авч үзвэл шинэ орон сууцны үнэ өмнөх оны мөн үеэс 9.1 хувиар, өмнөх улирлаас 1.3 хувиар өссөн байгаа бол хуучин орон сууцны үнэ өмнөх оноос 14.1 хувиар, өмнөх улирлаас 3.9 хувиар тус тус өссөн дүнтэй байна. Ийнхүү сүүлийн саруудад хуучин орон сууцны үнэ шинэ орон сууцны үнээс илүү өсөх хандлага ажиглагдаж байна.

Үндэсний баялгийн сангийн тухай хууль батлагдаж, энэ оны 5 дугаар сараас ипотекийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт нэмэгдсэн¹⁶, цалин, өрхийн орлогын өсөлтийг дагаад орон сууцны эрэлт өссөн, барилгын өртөг сүүлийн 3 улирлын турш нэмэгдсэн зэрэг нь орон сууцны үнэ өсөхөд нөлөөлж байна. Тэнхлэг Зууч компанийн мэдээллээр орон сууцны үнэ өөрчлөлт багатай хэвээр байгаа ч түүврийн бүсчлэл, байрлал, бизнес зэрэглэлийн орон сууцны эзлэх жин зэрэг ялгаатай байдлаас хамаараад орон сууцны үнэ өөр байх талтай юм.

Түрээсийн үнэ сүүлийн саруудад хурдтай нэмэгдэж, тайлант улиралд өмнөх оны мөн үеэс 22.0 хувиар, өмнөх улирлаас 12.7 хувиар тус тус өслөө. Аялал жуулчлалын салбар идэвхжиж, түрээсийн орон сууцны эрэлт нэмэгдсэн, орон сууцны үнэ нэмэгдэж

байгаа зэрэг нь түрээсийн үнэ ийнхүү нэмэгдэхэд нөлөөлж байна


Зураг 3.19 Орон сууцны үнэ, түрээсийн үнийн жилийн өсөлт



Эх сурвалж: ҮСХ, Тэнхлэг-Зууч

Цалин, өрхийн орлогын өсөлтийг дагаад орон сууцны үнэ-орлогын харьцаа сүүлийн 5 улирлын турш буурлаа. Үнэ-орлогын харьцаа ийнхүү үргэлжлэн саарч байгаа нь орон сууц худалдан авах чадвар сайжирч байгааг илтгэж байна. Түрээсийн үнийн өсөлт сүүлийн 3 улирал эрчимжсэнээр үнэ-түрээсийн харьцаа буурсан нь орон сууцны үнийн хөөсрөлтийн эрсдэл бага байгааг харуулж байна.

Зураг 3.20 Үнэ-орлого ба үнэ-түрээсийн харьцаа




Эх сурвалж: ҮСХ, Тэнхлэг-Зууч

Орон сууцны барилгын өртөг тайлант улиралд өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар өслөө. Үүнд, цалингийн өсөлттэй

¹⁶ Эхний 3 улирлын байдлаар 1.2 их наяд төгрөгийн зээл олгож, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 50 орчим хувиар нэмэгдсэн байна.

холбоотойгоор цалингийн зардал нэмэгдсэн нь гол нөлөөтэй байв. Тодруулбал, орон сууцны барилгын өртөг жилийн 8.9 хувиар өссөний 10.5 нэгж хувийг цалингийн зардал бүрдүүлсэн бол гадаад инфляц, ханш харьцангуй тогтвортой байснаар материалын өртөг 2.8 хувийн сөрөг нөлөө үзүүлсэн байна.

Зураг 3.21 Орон сууцны барилгын өртгийн жилийн өсөлт



Эх сурвалж: УСХ, Тэнхлэг-Зууч

Хөрөнгийн зах зээл

Тайлант улиралд ТОП-20 индекс өмнөх улирлаас 12.4 хувиар, зах зээлийн нийт үнэлгээ 9.6 хувиар өсөж түүхэн өндөр түвшинд хүрлээ. Үүнд, Худалдаа хөгжлийн банк, Голomt банк, Тавантолгой ХХК, Инвекор ББСБ, Монголын хөрөнгийн бирж зэрэг томоохон компаниудын эхний хагас жилийн орлого, цэвэр ашгийн үзүүлэлтүүд сайн гарч, хувьцааны үнэ өссөн нь гол нөлөөг үзүүллээ.


Зураг 3.22 Хөрөнгийн захын үзүүлэлтүүд



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Хөрөнгийн зах дээр тайлант улиралд 175.8 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийгдсэн бөгөөд энэ нь өмнөх улирлаас 433.3 тэрбум төгрөгөөр буурсан дүн юм. Харин Улаанбаатар бондын арилжааг хасаж тооцвол үнэт цаасны арилжаа өмнөх улирлаас 60 орчим хувиар өсөж, хөрөнгийн захын идэвхжил нэмэгдлээ (Зураг 3.23). Үүнээс компанийн бонд болон ХБҮЦ-ны арилжаа нэмэгдсэн бол хувьцаа, ХОС-гийн арилжаа өмнөх улирлын орчимд хадгалагдлаа.

Зураг 3.23 Нийт арилжаа, бүтцээр¹⁷



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжааны хувьд анхдагч зах зээл дээр “Инвекор ББСБ” 50.0 тэрбум төгрөгийн ХБҮЦ арилжсан бол хоёрдогч зах зээлд нийт 16.0 тэрбум төгрөгийн арилжаа

¹⁷ Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ), Хөрөнгө оруулалтын сан (ХОС)

хийгдэж, нийт дүнгээр компанийн бондын арилжаа өмнөх улирлаас 2.4 дахин нэмэгдлээ.

Тайлант улиралд Компанийн бондын 50.6 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж, арилжааны идэвх өмнөх улирлаас 2 дахин өсөв. Үүнд, хоёрдогч зах зээлд 40.6 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж өмнөх улирлаас арилжааны идэвх огцом нэмэгдсэн нь гол нөлөөтэй байв. Харин анхдагч зах зээлд Сэндли ББСБ 10.0 төгрөгийн өрийн хэрэгсэл гаргаж арилжив.

Хувьцааны арилжааны хувьд 57.8 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж, арилжааны идэвх өмнөх улирлын орчимд байв. Үүнээс, Хаан банк, Премиум Нэксус, Монголын хөрөнгийн бирж зэрэг компанийн хувьцаанууд идэвхтэй арилжигдав. ХОС-гийн хувьд 1.5 тэрбум төгрөгийн дүнтэй арилжаа хийгдэж өмнөх улирлаас 0.3 тэрбумаар буурсан дүнтэй байна.

3.3. Нэгдсэн төсөв болон Засгийн газрын өр

Нэгдсэн төсөв: 2024 оны эхний 10 сард төсвийн тэнцвэржүүлсэн орлого өмнөх оноос 25.9 хувиар өндөр төвлөрч, 23.9 их наяд төгрөгт хүрсэн бол зардалд 32.2 хувиар их буюу 22.3 их наяд төгрөг зарцуулжээ. Ийнхүү тэнцвэржүүлсэн тэнцэл 1.5 их наяд төгрөгийн ашигтай байв (Хүснэгт 3.2).

Тэнцвэржүүлсэн орлого 2024 онд: Нэгдсэн төсвийн орлогын бүх дэд бүлгүүд нэмэгдэж, эхний 10 сарын байдлаар нийт тэнцвэржүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 4.9 их наяд төгрөгөөр өслөө. Үүнд, эдийн засгийн идэвхжлийг даган ААНОАТ 1.8 их наяд төгрөг, ХХОАТ 560 тэрбум төгрөгөөр өссөн нь том нөлөөтэй байна (Зураг 3.25). Мөн импорттой холбоотой татварууд буюу импортын барааны НӨАТ 670 тэрбум төгрөгөөр, суудлын машины


онцгой албан татвар 226 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Хүснэгт 3.2 Төсвийн үндсэн үзүүлэлтүүд

Их наяд төгрөг	2024		2024.10	
	Тод.	Гүй.	Гүй.	%
Нийт орлого	30.6	25.5		83.3
Сангийн орлого	1.8	1.6		88.9
Тэнцвэржүүлсэн орлого	28.9	23.9		82.7
Татварын орлого	26.9	22.3		82.9
Татварын бус орлого	1.9	2.0		105.3
Нийт зардал	30.5	22.3		73.1
Анхдагч зардал	29.3	21.3		72.7
Хүүний зардал	1.2	1.1		91.7
Нийт тэнцэл	0.1	3.1		
ДНБ-д эзлэх хувь	0.2%	3.9%		
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-1.6	1.5		
ДНБ-д эзлэх хувь	-2.0%	1.9%		
Анхдагч тэнцэл	-0.4	2.6		
ДНБ-д эзлэх хувь	0.5%	2.4%		

Эх сурвалж: Сангийн яам

Зураг 3.24 Төсвийн орлогын бүтэц, 2024.I-X




Эх сурвалж: Сангийн яам

Нийт зардал, цэвэр зээл: Эхний 10 сарын төсвийн зардал оны мөн үеэс 32.2 хувиар буюу 5.4 их наяд төгрөгөөр өндөр байв (Хүснэгт 3.25). Үүнээс урсгал зардал 4.0 их наяд төгрөгөөр нэмэгдсэний 3.3 их наяд төгрөгийг бараа, үйлчилгээний зардалд зарцуулжээ. Үүнд цалингийн зардал 2.4 их наяд орчим төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөллөө. Мөн хөрөнгийн зардал 1.3 их наяд төгрөгөөр нэмэгдсэний 592 тэрбум төгрөг нь хөрөнгө оруулалтын зардалд, 534

тэрбум төгрөгийг геологийн хайгуулын зардалд тус тус зарцуулжээ (Зураг 3.26).

Зураг 3.25 Төсвийн зардлын бүтэц



Эх сурвалж: Сангийн яам

Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын нийт өр: Засгийн газрын нийт өрийн ДНБ-д эзлэх хувь 2024 оны эхний 3 улирлын байдлаар 38.9 хувь байсан нь хуульд заасан хязгаарыг хангаж байна (Хүснэгт 3.3). Засгийн газрын өрийн хязгаарыг 2024 оны тодотгосон төсөвт 60 хувь байхаар тооцсон.

Хүснэгт 3.3 Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өр болон зээлийн үйлчилгээний төлбөр

тэрбум төгрөг	2022		2023		2024. III		2024*	
	Гүй	Гүй	Гүй	Гүй	Бат.	Тод	Бат.	Тод
Засгийн газрын нийт өр	31965	30774	30814	39276	39276	31449	39276	31449
ДНБ-д эзлэх хувь	60.5	44.7	38.9	53.1	53.1	39.7	53.1	39.7
Өрийн хязгаар	70.0	65.0	60.0	60.0	60.0	60.0	60.0	60.0
Зээлийн үйлчилгээний төлбөр	816	1132	4018	1174	1174	1174	1174	1174
Төсвийн орлогод эзлэх хувь	4.7	4.9	5.5	4.5	4.5	4.1	4.5	4.1
Төсвийн тэнцэл	-1032	785	1469	-1833	-1833	-1615	-1833	-1615
ДНБ-д эзлэх хувь	-1.9	1.1	1.8	-2.0	-2.0	-2.0	-2.0	-2.0

Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк

4. ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ОРЧИН

4.1 Эдийн засгийн гадаад орчны төсөөлөл

Гадаад эрэлт: Олон улсын байгууллагуудын төсөөллөөр дэлхийн эдийн засгийн өсөлт өмнөх улирлын төсөөллөөс өөрчлөгдөөгүй буюу энэ онд 3.1 хувь, 2025 онд 3.2 хувь байна.

Зураг 4.1 Улс орнуудын өсөлтийн төсөөлөл



Эх сурвалж: Блүмберг, Рубини, EIU, ОУВС, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагуудын төсөөллийн дундаж

БНХАУ-ын өсөлт 2024 оны 3-р улиралд 4.6 хувьтай гарлаа. Тус улсын үл хөдлөх хөрөнгийн салбарын хямрал үргэлжилж, хувийн хэрэглээ сэргэхгүй байгаа нь энэ оны өсөлт 5.0 хувийн зорилтдоо хүрэхэд эрсдэл үүсгэж байна. Үүнээс шалтгаалан Ардын банкнаас бодлогын хүүг буулгах, заавал байлгах нөөцийн хувийг бууруулах, үл хөдлөх хөрөнгийн салбарыг дэмжих, хөрөнгийн зах зээлийг сэргээхэд чиглэсэн багц арга хэмжээг 9-р сард танилцуулсан ч энэ нь 2024 оны өсөлтийн зорилтдоо хүрэхэд хангалтгүй байгааг шинжээчид онцоллоо.

БНХАУ-ын хүн амын тоо буурч буй, хот руу шилжих хөдөлгөөн удааширсан, үл хөдлөх салбар дахь эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр алдагдсан, хувийн секторын хөрөнгө оруулалт буурсан зэрэг хүчин зүйлсээс хамааран ирэх онуудад өсөлтийн хурд саарах хүлээлттэй. Энэ төсөөлөлд Дональд

Трампын хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний нөлөө тусаагүй болно.


АНУ-ын эдийн засаг 2024 оны 3-р улиралд төсөөллөөс өндөр буюу жилийн 2.7 хувиар өсөв. Энэхүү өсөлтөд хувийн хэрэглээ, засгийн газрын хэрэглээний өсөлтөөс гадна гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдсэн нь чухал нөлөөтэй байв. Шинэчилсэн төсөөллөөр өсөлт энэ онд 2.7 хувь, 2025 онд 2.0 хувь байх төлөвтэй. Энэхүү төсөөлөлд АНУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдоод байгаа Дональд Трампын хэрэгжүүлэхээр амласан бодлогын нөлөө ороогүй тул дараагийн улирлаас өсөлтийн төсөөлөлд томоохон өөрчлөлт гарч болзошгүй байна.

Евро бүсийн эдийн засаг энэ оны 3-р улиралд жилийн 0.9 хувиар өсөв. Өсөлтөд үйлчилгээний салбарын өсөлт хамгийн том эерэг нөлөөг үзүүллээ. Герман, Итали зэрэг улсуудад боловсруулах салбарын идэвхжил сул байгаа нь өсөлтийг бууруулах шалтгаан болж байна. Евро бүсийн өсөлт 2024 онд 0.7 хувь, 2025 онд 1.2 хувь байх төсөөлөл хэвээр байна.

ОХУ-ын эдийн засаг 2024 оны 3-р улиралд дахин шинжээчдийн хүлээлтээс давж, жилийн 3.1 хувиар өсөв. Улмаар энэ оны өсөлтийн төсөөлөл 0.4 пунктээр нэмэгдэж 3.8 хувьд хүрсэн бол 2025 онд мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр 1.5 хувь болж буурах төлөвтэй.

Гадаад инфляц: Дэлхийн ихэнх оронд инфляцын эрч саарсаар байгаа ч төв банкуудын зорилтот түвшинээс өндөр хэвээр байна.

Зураг 4.2 Улс орнуудын инфляцын төсөөлөл



Эх сурвалж: Блүмберг, Рубини, EIU, ОУВС, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагуудын төсөөллийн дундаж

БНХАУ-ын инфляц 10-р сард жилийн 0.3 хувь байв. Түүнчлэн, үйлдвэрлэгчийн үнийн индекс 2022 оны 10-р сараас хойш 25 сар дараалан жилийн өмнөх үеэс буураад байгаа нь дотоод эрэлт сул байгааг харуулсаар байна.

АНУ-ын жилийн инфляц 2024 оны 10-р сарын байдлаар 2.6 хувь буюу өмнөх улиралд төсөөлж байснаас бага гарав.

ОХУ-ын инфляц 10-р сарын байдлаар 8.5 хувьд хүрч, сүүлийн 2 сар дараалан буурав. Хэдий тийм ч энэ нь төв банкны зорилт болох 4.0 хувиас 2 гаруй дахин өндөр дүн юм.

Гадаад хүү: ХНБ-ны энэ оны 9-р сарын хурлаар бодлогын хүүгээ 0.5 нэгж хувиар бууруулаад байсан бол 11-р сарын хурлаар дахин 0.25 нэгж хувиар бууруулж 4.5-4.75 хувийн интервалд хүргэлээ. Ихэнх шинжээчид энэ оны 12-р сард болох хурлаар ХНБ бодлогын хүүгээ дахин 0.25 нэгж хувиар бууруулах таамаг дэвшүүлээд байна. Түүнчлэн, АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трампын хэрэгжүүлэх бодлогын нөлөөгөөр цаашид инфляцын төсөөлөл нэмэгдэх, үүнээс шалтгаалж ирэх жилүүдэд ХНБ бодлогын хүүгээ өмнөх улиралд төсөөлж байснаас илүү өндөрт хадгалах хүлээлт зах зээлд үүсэв. Харин Евро бүсийн инфляц хүлээлтийн дагуу буурч байгаа тул Европын төв банк энэ оны 6-р сараас эхлэн

3 удаагийн хурлаар бодлогын хүү бууруулах шийдвэр гаргаад байна.

БНХАУ-ын Ардын банкнаас эдийн засгаа дэмжих бодлогын багц арга хэмжээний хүрээнд өөрсдийн ашигладаг гол хүүнүүдээ бууруулах шийдвэр гаргав. Эсрэгээрээ ОХУ-ын инфляц өндөр гарсан тул тус улсын төв банк 10-р сарын 25-ны өдрийн хурлаар бодлогын хүүгээ нэмэгдүүлж, 21 хувь буюу 2003 оноос хойших хамгийн өндөр түвшинд хүргээд байна.

4.2.Экспортын үнийн төлөв

Зэс: Зэсийн үнэ 2024 оны 3-р улирлын дунджаар 9430 ам.доллар/тн буюу төсөөллөөс 100 ам.доллар/тн-оор бага байв. Нэг талаас зэсийн нийлүүлэлт тогтвортой байсан бол нөгөө талаас гол хэрэглэгч БНХАУ-ын эрэлт сул байж, эдийн засгийн үзүүлэлтүүд хүлээлтээс тааруу гарсан нь ийнхүү үнэ бага байхад нөлөөллөө. Харин 2025 онд зэсийн орц өндөртэй цахилгаан автомашины үйлдвэрлэл, нар, салхины сэргээгдэх эрчим хүчтэй холбогдсон төслүүдийн хөрөнгө оруулалт хурдтай нэмэгдэж улмаар зэсийн үнэ өсөх хүлээлт зах зээлд давамгайлж байна.

Алт: Алтны үнэ 2024 оны 3-р улиралд үргэлжлэн өсөж, түүхэн өндөр утгыг дахин шинэчлэв. Геополитикийн хурцадмал байдал үргэлжилсэн хэвээр байгаа нь алтанд хөрөнгө оруулах сонирхлыг өдөөсөөр байна. Үүний зэрэгцээ БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбар хүндрэлтэй байгаагаас тус улсын хөрөнгө оруулагчид алтны эрэлтийг нэмэгдүүлж байна. Мөн хөгжиж буй орнуудын төв банкууд зах зээлийн тодорхой бус байдлаас шалтгаалан алтны эрэлтийг өдөөж буйг шинжээчид онцоллоо. Дональд Трамп АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд ялснаар алтны үнэ бага зэрэг буурах хандлага ажиглагдаж

байгаа ч ирэх оны алтны үнийн төсөөлөл өмнөхөөс нэмэгдлээ.

Коксжих нүүрс: Коксжих нүүрсний хилийн үнэ 3-р улиралд төсөөллөөс бага байв. БНХАУ-ын эдийн засгийн идэвхжил сул байгаагаас гангийн эрэлт буурч, улмаар коксжих нүүрсний эрэлт багасч байна. Шинжээчдийн хүлээлтээр цаашид ч энэ байдал үргэлжлэх төлөвтэй байгаа тул 2025 оны нүүрсний үнийн төсөөллийг өмнөх төсөөллөөс 10 ам.доллар/тн-оор буурууллаа. Хэдийгээр нүүрсний үнэ үргэлжлэн буурахаар байгаа ч ирэх оны үнэ 2019 оны дунджаас 5 ам.доллар/тн-оор өндөр юм.

Төмрийн хүдэр: 3-р улирлын дунджаар тонн тутамдаа 98 ам.доллар болж өмнөх улирлаас 7.9 хувиар буурав. Ийнхүү төмрийн хүдрийн үнэ хүлээлтээс доогуур байгаа нь БНХАУ-ын эдийн засгийн идэвхжил сул байгаатай холбоотой юм. Ирэх жилүүдэд тус улсын эдийн засгийн өсөлт өмнөх онуудаас саарах, үл хөдлөхийн салбарын хүндрэл үргэлжлэх хүлээлт хэвээр байгаа тул төмрийн хүдрийн үнэ буурах төсөөлөлтэй байна.

Газрын тос: Brent газрын тосны үнэ 23-р улирлын дунджаар 77.1 ам.доллар/баррель буюу төсөөллөөс 7 ам.доллар/баррель-аар бага байв. Ийнхүү гүйцэтгэл бага гарахад газрын тосны нийлүүлэлт тогтвортой үед эрэлт бага байсан нь нөлөөллөө. Үүнд, БНХАУ-ын газрын тосны эрэлт хүлээлтээс бага байсан нь хамгийн том нөлөөтэй байсныг шинжээчид онцлов. Нөгөө талаас геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалж газрын тосны үнэ хэлбэлзэл өндөртэй байв. АНУ-ын шинээр сонгогдсон Ерөнхийлөгч Дональд Трампын хувьд газрын тосны олборлолтоо нэмэгдүүлэхийг зорьдог тул цаашид АНУ-ын газрын тосны нийлүүлэлт одоогийн өндөр түвшинд хадгалагдах

хүлээлттэй байна. Нөгөө талаас цахилгаан автомашины хэрэглээний өсөлт, Европ болон хөгжиж буй эдийн засгууд дахь газрын тосны эрэлтийн өсөлт саарч буй зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр ирэх онуудад газрын тосны үнэ буурах төлөвтэй.

Худалдааны нөхцөл: Нүүрс, төмрийн хүдэр, газрын тосны үнэ хүлээлтээс бага гарч, улмаар цаашдын төсөөлөл ч буурав (Зураг 4.3). Ойрын 2 жилд импортын үнийн өсөлт харьцангуй бага байх бол экспортын үнийн бууралтаас голлон шалтгаалж худалдааны нөхцөл муудах хүлээлт хэвээр байна.

Зураг 4.3 Худалдааны нөхцөл, экспорт, импортын үнийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголбанкны тооцоолол

4.3.Төлбөрийн тэнцэл


Төлбөрийн тэнцэл энэ оны III улиралд 193 сая ам.доллар, эхний 3 улиралд 251 сая ам.долларын алдагдалтай байв. Үүнд дараах хүчин зүйлс голлон нөлөөллөө.

- Гадаад худалдааны ашиг буурч байна. Нүүрсний экспортын биет хэмжээ өссөн хэдий ч үнийн бууралтаас шалтгаалан экспортын орлогын өсөлт саарлаа. Харин импортын өсөлт өндөр хэвээр байна. Эдийн засгийн идэвхжил нэмэгдэхийн зэрэгцээ төсвийн зардал эрчтэй тэлсэн нь

импортыг өдөөх гол шалтгаан болж байна.

- Үйлчилгээний зориулалттай гадаад төлбөрүүд, тэр дундаа хувийн аялал, боловсрол, эрүүл мэндийн гадаад зардал энэ онд нэмэгдлээ.
- Мөн Монголбанкнаас БНХАУ-ын Ардын банктай байгуулсан своп хэлцлийн үндсэн төлбөрөөс 4.5 тэрбум юань буюу 621 сая ам.долларыг төлсөн нь төлбөрийн тэнцлийн алдагдал өсөхөд нөлөөлсөн.

Зураг 4.4 Урсгал дансны алдагдал тэлснээр төлбөрийн тэнцэл алдагдалтай гарлаа.



Эх сурвалж: Монголбанк

Төлбөрийн тэнцлийг гол бүрэлдэхүүн хэсгүүдээр дэлгэрүүлж тайлбарлавал:

Экспортын орлогын өсөлт өмнөх жилд 21.1 хувьд хүрч нэмэгдээд байсан бол 2024 оны эхний 3 улиралд 4.8 хувь болж саарлаа. Үүний 2.3 нэгж хувийг зэсийн экспорт, 2.1 нэгж хувийг нүүрсний экспорт тайлбарлаж байна. Нүүрсний экспортын биет хэмжээ 61.2 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 25 хувиар нэмэгдсэн хэдий ч үнэ өмнөх оны эхний 3 улирлын дунджаас 26\$¹⁸-оор багассанаар экспортын орлогын өсөлт ийнхүү саарав. Харин төмрийн хүдрийн биет хэмжээ өссөн, алт, зэсийн үнэ нэмэгдсэн нь экспортын орлогын өсөлтөд эерэг нөлөөтэй байв.

¹⁸ Энэ нь 19 хувиар буурсан үзүүлэлт юм.

Хүснэгт 4.1 Экспортын орлогын өсөлтийг алт, зэсийн орлого бүрдүүлж байна.

сая ам.доллар	2023 III	2024 III	Жилийн өсөлт %	Өсөлтөд эзлэх %
Нийт экспорт	3,732	3,896	4.4	4.4
Чулуун нүүрс	2,087	1978	-5.2	-2.9
Зэсийн хүдэр, баяжмал	670	810	20.9	3.8
Төмрийн хүдэр, баяжмал	94	154	63.3	1.6
Мөнгөжөөгүй алт	223	315	40.9	2.4
Ноолуур	171	134	-21.4	-1.0
Боловсруулаагүй нефть	96	83	-13.3	-0.3
Мах, махан бүтээгдэхүүн	66	70	6.5	0.1
Бусад самар	5	9	73.4	0.1
Жонш, лейцит, нефелинт	68	85	24.8	0.4
Мөнгөний хүдэр, баяжмал	28	51	83.6	0.6
Молебдиний хүдэр, баяжмал	20	19	-7.9	0.0
Цайрын хүдэр, баяжмал	27	46	69.1	0.5
Бусад	176	143	-19.1	-0.9

Эх сурвалж: ГЕГ

Импортын жилийн өсөлт оны эхний 3 улирлын турш эрчимтэй өсөж, 27.4 хувьд хүрлээ. Импортын бүхий л дэд бүлгийн өсөлт нэмэгдэж байна. Тухайлбал, уул уурхайн экспорт, тэр дундаа нүүрсний экспортын биет хэмжээ өсөж байгаа нь том машин, механизм болон дизель түлшний импортын эрэлт өсөх гол шалтгаан болсоор байна. Түүнчлэн төсвийн зардал оны эхний 3 улиралд жилийн 34 хувиар тэлсэн нь барааны төдийгүй үйлчилгээний импортын зардлыг нэмэгдүүлж байна.

Хүснэгт 4.2 Импортын өсөлт эрчимжиж, III улиралд 30.1 хувьд хүрлээ.


сая ам.доллар	2023 III	2024 III	Жилийн өсөлт %	Өсөлтөд эзлэх %
Нийт импорт	2,482	3,230	30.1	30.1
Хэрэглээний бүтээгдэхүүн	677	1,027	51.6	14.1
Түргэн эдэлгээт	330	447	35.4	4.7
Удаан эдэлгээт	347	579	67.0	9.4
Сүүдлын автомашин	218	427	95.7	8.4
Хөрөнгө оруулалтын бүт.н	1,084	1,389	28.1	12.3
Нефтийн бүтээгдэхүүн	488	563	15.3	3.0
Дизель	279	339	21.7	2.4
Бусад шатахуун	210	224	6.7	0.6
Аж үйлдвэрлэлийн орц	228	247	8.3	0.8
Бусад	4.2	4.4	4.8	0.0

Эх сурвалж: ГЕГ, Монголбанк

Үйлчилгээний дансны алдагдал өндөр хэвээр байна. Үүнд хувийн аялал, боловсрол, эрүүл мэндийн зориулалттай үйлчилгээний зардал оны эхний 3 улиралд өмнөх жилээс 314 сая ам.доллаар нэмэгдсэн нь голлон нөлөөлж байна. Харин

үйлчилгээний дансны орлого өмнөх жилийн мөн үеэс төдийлөн сайжраагүй байна (Зураг 4.55).


Зураг 4.5 Үйлчилгээний дансны алдагдал өндөр хэвээр байна.



Эх сурвалж: Монголбанк

Орлогын дансны алдагдал эхний 3 улиралд өмнөх жилээс 500 сая ам.доллаар өсөж, 2 тэрбум ам.долларт хүрэв. Оюу толгойн хөрөнгө оруулагчийн зээлийн хүлээгдэж буй хуримтлагдсан хүүний төлбөр өсөхийн зэрэгцээ гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгжүүдийн ашигт ажиллагаа сайжирснаар хөрөнгө оруулагчдад хуваарилах ногдол ашгийн дүн нэмэгдлээ.

Зураг 4.6 Орлогын дансны алдагдал тэлж байна.




Эх сурвалж: Монголбанк

Санхүүгийн дансны тэнцэл оны эхний 3 улиралд 1.3 орчим тэрбум ам.долларын ашигтай байв. Нэг талаас Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилт шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг

голлон бүрдүүлсэн хэвээр байна. Мөн Голомт банкны 5-р сард гаргасан 300 орчим сая ам.долларын бонд, Хөгжлийн банкны 3-р сард олон улсын зах зээлээс татсан 200 сая ам.долларын бонд багцын хөрөнгө оруулалтын орох урсгалыг сайжрууллаа.

Зураг 4.7 Санхүүгийн данс 2024 оны эхний 9 сард 1.3 тэрбум ам.долларын ашигтай байв.



Эх сурвалж: Монголбанк

